



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Цацраг идэвхт ашигт малтмалын салбарт
авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний
талаар чиглэл өгөх тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5, 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2, 4.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн Цөмийн энергийн комиссоос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын ураны батлагдсан нөөцийг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор “Мон-Атом” ХХК-д цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг судлан шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Г.Ёндон), Ашигт малтмал, газрын тосны газар (Б.Түвшинжаргал)-т тус тус чиглэл болгосугай.

2. “Гурвансайхан” ХХК, “Бадрах энерги” ХХК-тай байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн гэрээний хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Г.Ёндон)-нд даалгасугай.

3. Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолтод ашиглах хүхрийн хүчлийг дотоодоос хангах боломжийг судалж, танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Г.Ёндон), “Эрдэнэс Монгол” ХХК (О.Хулан)-д тус тус үүрэг болгосугай.

4. Цацраг идэвхт ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх, төслүүдийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Г.Ёндон), Ашигт малтмал, газрын тосны газар (Б.Түвшинжаргал)-т тус тус чиглэл болгосугай.
Үүнд:

- “Бадрах Энержи” ХХК-иас Зөөвч Овоо ураны ордод хэрэгжүүлж буй үйлдвэрлэлийн туршилтын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах;
- Улааны ураны ордын талбайн хил заагийг тогтоох, “Шинь шинь” ХХК-тай хамтарсан компани байгуулж, төрийн эзэмшлийн хувь хэмжээг Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу тогтоох.

5. Цөмийн энерги ашиглах, ураны хайгуул, олборлолттой холбоотой үнэн бодит мэдээллийг олон нийтэд сурталчилан таниулах ажлыг эрчимжүүлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК (О.Хулан), “Мон-Атом” ХХК (Д.Далайжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд даалгасугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,
КОМИССЫН ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН